

“БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 03 сарын 20-ны өдөр

№ 05/25

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх заалт, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4 дэх заалт, 64 дүгээр зүйлийн 64.2 дахь заалт, 65 дугаар зүйлийн 65.1, 65.4 дэх заалт, 71 дүгээр 71.1, 71.3, 71.4 дэх заалт, 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3 дахь заалтууд болон Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ыг үндэслэн компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ НЬ:**

1. “БидиСЕК ҮЦК” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 4 сарын 30-ны өдөр 11 цагт Улаанбаатар хотод цахим хэлбэрээр хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай.
 - а) Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах
 - б) Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах
 - с) Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах
 - д) Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
 - е) Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны төсөв батлах
3. Хурлыг зарлах тухай мэдэгдлийг 2025 оны 03 сарын 21-ний өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид тус тус хүргүүлсүгэй.
4. Хурал хуралдуулах тухай зар мэдээг Монголын хөрөнгийн биржийн цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр буюу өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг радио, телевизийн аль нэгээр болон компанийн цахим

хуудсаар дамжуулан 2025 оны 03 сарын 24-ний өдөр нийтэд мэдээлж, уг зарыг 2025 оны 04 сарын 08-ны өдөр дахин нийтэд мэдээлсүгэй.

5. Ногдол ашиг авах болон хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 04 сарын 10-ны өдрөөр тогтоосугай.
6. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гарах шийдвэрийн төсөл, танилцуулга саналын хуудас зэрэг бусад холбоотой баримт бичгийг 2025 оны 03 сарын 27-ны өдөрт багтаан үнэт цаасны брокер дилерийн компанид хүргүүлсүгэй.
7. Хурлын зарын загвар, хэлэлцэх асуудлыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
8. Хурлын дэгийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
9. Хурлын танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг гуравдугаар хавсралтаар баталсугай
10. Хурлын саналын хуудасны загварыг дөрөвдүгээр хавсралтаар баталсугай.
11. Хурлын материалыг 2025 оны 03 сарын 27-ны өдөр брокер, дилерийн компаниудад хүргүүлж, хувьцаа эзэмшигчдэд Хурлын материалтай ажлын өдрийн 10:00-17:00 цагийн хооронд танилцах боломж бүрдүүлэхийг Гүйцэтгэх захирал болон Хурал зохион байгуулах комисст даалгасугай.
12. Хуралд биечлэн оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчдэд саналаа урьдчилан өгөх боломжоор хангаж Компанийн өөрийн байранд урьдчилсан саналын хуудсыг хүлээн авах ба саналын хуудсыг хүлээн авах сүүлийн хугацаа 2025 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн 15:00 цаг байна.
13. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссын даргаар Г.Энхжин, гишүүнээр Э.Пүрэвжаргал нарыг тус тус томилсугай.
14. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Д.Даянбилгүүн, тооллогын комиссын даргаар “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн Хөрөнгө оруулалтын албаны захирал С.Дөлгөөн, гишүүнээр “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн мэргэжилтэн Б.Хулан нарыг тус тус томилсугай.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:**



/Д.ДАЯНБИЛГҮҮН/

“БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 03 сарын 20-ны өдөр

№ 06/25

Улаанбаатар хот

Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх заалтыг үндэслэн компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайланг хангалттай гэж дүгнэсүгэй.
2. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт, тайланг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хэлэлцүүлэхийг ТУЗ-ийн дарга (Д.Даянбилгүүн)-д даалгасугай.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:**



/Д.ДАЯНБИЛГҮҮН/

“БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 03 сарын 20-ны өдөр

№ 07/25


Улаанбаатар хот

Компанийн бизнес төлөвлөгөөг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.2.12 дэх заалтыг үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Компанийн бизнес төлөвлөгөөг энэхүү тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсугай.
2. Компанийн бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Лхагвадорж)-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:



/Д.ДАЯНБИЛГҮҮН/